

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ**
TO THE ISSUES OF THE ENHANCEMENT ON THE SOME LEGAL COORDINATIONS
OF ADMINISTRATIVE PROCESS LAW OF MONGOLIA

Э.Анхбаяр

*Шихихутуг Их сургуулийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч*

Товч агуулга. 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино¹ хэмээн хуульчилсан байна. Түүнчлэн, тухайн хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: гээд “3.1.9."захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд" гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг,” гэж заасан байна.

Харин Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна” гэжээ. Үүнээс харахад, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэхэмжлэл гаргах эрхийн хүрээг зааснаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, захиргааны эрх зүйн онол баримтлалыг үл харгалзан эрх зүйн зохицуулалтын алдаа гаргасан байна. Иймээс эрх зүйн онол, зарчмын хүрээнд шинжлэх ухаанч ага барилаар аль болох цаг алдалгүй засаж залруулах нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт хэрэгжих, нийтийн ашиг сонирхол бүрэн хамгаалагдах бодит нөхцөл бүрдэхээр байна.

Abstract. The objective of 2016 Administrative Process Law of Mongolia is legalized “to regulate relations to resolve administrative cases at the Court in conformity with the claims made by persons and legal entities or by the claims of public interest organizations or administrative organizations if stated so in the relevant law to complain about the breaches or probable breaches of their rights and legal interests due to illegal actions of administrative organizations”². Moreover, terms used in the law shall be understood as follows: “...3.1.9." public interest organizations at the administrative court" is referred to as a person enhanced with the rights in conformity with the law or non-governmental organization that meets requirements stipulated in Article 18.3 of the Law...”.

However, Article 18.3 of the Administrative Process Law of Mongolia states, persons or organizations with the rights to represent the public interests shall be entitled to make claims at Court on the issues of nature and environment, children’s rights, public health, and public asset protection issues upon enhancement of the following requirements. It means the statements of the legal frameworks for the persons or organizations with the rights to represent the public interests have breached the legal coordination mistakes upon ignorance of the administrative law and

¹ <https://legalinfo.mn/mn/detail/11703>

² <https://legalinfo.mn/mn/detail/11703>

Administrative Process Law theoretical tendencies. Thus, immediate corrections of these mistakes in scientific ways within the framework of legal theories and principles shall create the real conditions and circumstances to enhance the implementation and enforcements of Administrative Process Law and to protect public interests fully.

Түлхүүр үг: Нийтийн ашиг сонирхол, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч.

Key words: Public interest, Entity authorized to represent public interest in court, surrounding environment, children's rights, public health, public assets.

Үндсэн хэсэг

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна гэжээ. Үүнд нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх мөн дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх³ гэж эрх зүйн зохицуулалт хийсэн байна.

Дээрх эрх зүйн зохицуулалтыг 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Монгол улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 30 дугаар тогтоолын 5.1-г:

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “,,нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, байгаль хамгаалал, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжих:” гэж тусгасны дагуу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг 2015 онд боловсруулж батлахдаа нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг тодорхойлж, “нийтийн ашиг сонирхол”-д хамаарч болох нэхэмжлэлийн шаардлагын хүрээг заажээ. Тодруулбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэж” хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг (ойлгохоор)”, 18 дугаар зүйлийн 3-т “хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна: 18.3.1. нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх; 18.3.2. дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэж тус тус тодорхойлсон байна. Түүнчлэн, “,,хуулийн энэхүү зохицуулалтыг тайлбарлахдаа хууль санаачлагч болон хууль тогтоогчийн үзэл баримтлал, хуулийн зорилго болон хууль тогтоогчийн үзэл баримтлал, хуулийн зорилго болон бусад зохицуулалтын уялдааг харгалзан системчилсэн байдлаар авч үзэх нь зүйтэй гээд тухайн тайлбарын 5.1.1-т, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т зааснаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг “хуулиар тусгайлан эрх олгогдсон” этгээд болон уг хуульд тусгайлан заасан шаардлага нөхцөлийг хангасан “нийтийн ашиг” сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэсэн хоёр субьектэд олгохоор хуульчилсан, түүнчлэн “хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь “,,(энэ хуульд заасан) шаардлагыг хангасан байна” гэж заажээ.

³ 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3.1, 18.3.2.

Хууль тогтоогч “хуулиар тусгайлан эрх олгогдсон” хэмээн эш татсан гипотезыг хэрэглэхдээ “тусгайлан” гэх угтвар нөхцөлийг онцгойлон хуульчилсан учир нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг тухайн хуулиар өөр бусад хуулиар тусгайлан олгосон байхыг шаардана, харин уг этгээд нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шалгуурыг хангасан байхыг шаардахгүй гэж ойлгохоор байна” гэж тайлбарласан байна.

2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Монгол улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 30 дугаар тогтоолыг нэгтгэн дүгнэвэл: Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хуулиар тусгайлан олгосон этгээд /Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шалгуурыг хангасан байхыг шаардахгүй/ “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд” гэж ойлгохоор байна.

Мөн тухайн талбартаа: Хуулийн 18 дугаар зүйлээр хууль тогтоогч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд нь “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах” зорилго, агуулгаар нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахаар “агуулга”-ын хүрээг тогтоосон, энэ хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэхдээ хууль санаачлагч болон хууль тогтоогчийн хүсэл зоригийг анхаарах нь зүйтэй байна гээд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа хэрэгцээ шаардлага, төслийн үзэл баримтлал, түүнийг Улсын Их Хурлаас хэлэлцэж баталсан холбогдох тэмдэглэл зэргээс үзэхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хүрээг “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах” гэж тогтооход буюу тодорхой хязгаартай нээхэд чиглэжээ” хэмээн тайлбарласан байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын Дээд шүүхийн тайлбарыг харахад, дараах ойлголтыг судлах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байна. Үүнд: 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт хэсэгт тусгасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэж хэн байх, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хүрээг “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах” гэж тогтоосон нь оновчтой эрх зүйн зохицуулалт мөн үү? гэдгийг судлах.

Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт хэсэгт тусгасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийг тодорхойлохын тулд нийтийн ашиг сонирхлыг онолын хувьд хэрхэн тайлбарладаг, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хүрээг зөвхөн хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийн асуудлаар хязгаарласан нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийнхаа үзэл баримтлалд нийцсэн эсэх, түүний үр дагаврыг судлахыг зорилоо

Нийтийн ашиг сонирхлын илэрхийлэл анх 17 дугаар зуунд “төр”, төрийн “удирдлага” нэрээр дарангуйлсан хэмжээгүй эрх хаант засаглалыг халах нийтийн сайн сайхны төлөө тэмцлээр эхэлж нэг үе мандаж, нэг үе хүчин мөхсөдөж явсаар баруун Европт 17 дугаар зууны эхэн үеэс улам бүр хүчээ авч нийгмийн харилцаан дахь дангаар ноёрхсон дарангуйлах ёс дэглэмийг иргэд нийтийн хөдөлгөөнөөр өөрчлөн шинэтгэж иргэдэд үйлчилдэг үйлчилгээний байгууллага болгосон түүхтэй. Товчдоо бол бүр Аристотелийн үеэс л “нийгэм гэдэг бол нэгдмэл зорилгын төлөө ажиллаж амьдарч, аж төрж буй хүмүүсийн нэгдсэн зохион байгуулалт, нийтийн ашиг сонирхол мөн” гэдгийг эрдэмтэн мэргэд зуун зуун дамжин хүлээн зөвшөөрсөөр иржээ.

Дээрх эрх зүйн онолын үзэл баримтлал, чиг хандлага 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд⁴ зохих тусгалаа олж нийтийн хүртэл болон хөгжиж байна.

“Нийтийн сонирхол /Public interest/: Ерөнхий утгаар нь авч үзвэл нийтийн сонирхол нь нийт ард түмэн ба нийгмийн сайн сайхан байдлыг хангах хэмээн хэлж болно. Уг ойлголтыг нарийвчлан тодорхойлоход бэрхшээлтэй. Эрдэмтэн судлаачид янз бүрийн санал дэвшүүлснийг гурван үндсэн загварт авч үздэг. Нэгд, нийтийн сонирхол давамгайлах загвар, хоёр: Нийлбэр сонирхлын загвар, гуравт: Нэгдмэл сонирхлын загвар. Эхний загвар нь нийтийн сонирхол хувь хүний сонирхлоос дээгүүр байж, илүү ач холбогдолтой гэж үздэг бол хоёр дахь загварын төлөөлөгчид нийтийн сонирхол бол хувь хүмүүсийн сонирхлын нийлбэр гэдэг. Харин гуравдах буюу нэгдмэл сонирхлын загварыг баримтлагчид нийтийн сонирхол гэдэг бол тодорхой суурь зарчмуудад суурилсан янз бүрийн сонирхлын өрсөлдөөний явцад тодорхойлогдоно хэмээн үздэг. Нийтийн сонирхол нь хүн бүрийн сонирхлын нийлбэр байх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Учир нь бүх хүний сонирхлыг хангах боломжгүй юм. Нэгдмэл загвар нь орчин үеийн либерал ардчиллын шинж чанартай холбоотой”⁵ Өөрөөр хэлбэл нийтийн ашиг сонирхол өргөн хүрээний онолын ойлголт болох нь харагдаж байна.

2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн *нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд*, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино⁶ гэж хуульчилсан нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд /төрийн бус байгууллага/ нэхэмжлэл гаргах эрхийг нээж өгсөн ач холбогдолтой зохицуулалт бөгөөд энэ нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага, төслийн үзэл баримтлал, хууль санаачлагч болон хууль тогтоогчийн хүсэл зоригийн илэрхийлэл мөн гэж үзэхээр байна.

Түүнчлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухайн 3.1.3. "нэхэмжлэл" гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг хэлнэ⁷ гэж хуульчилсан нь хуулийн үзэл баримтлалыг улам бүр тодруулсан зохицуулалт болсон байна. Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхэд захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх хууль, ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргах бөгөөд нэхэмжлэлийг хэн гаргах эрхтэй талаарх зохицуулалт бөгөөд захиргаа нь хэрхэн нийтийн ашиг сонирхол хангаж хамгаалдаг, мөн зөрчдөг, зөрчиж болзошгүй шийдвэр үйл ажиллагаа явуулдаг талаарх судалгааг хийснээр хуулийн үзэл баримтлалыг онолын хувьд тайлбарлах ач холбогдолтой байна. Мөн захиргаа нь зөвхөн хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шийдвэр үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд нийтийн эрх ашиг сонирхол гэдгийг ингэж явцууруулах нь зөв эсэхэд дүгнэлт өгөх ач холбогдолтой байна.

⁴ Дам ишлэв: Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Тэргүүн дэвтэр. УБ., (2000). 51. 55 дахь тал, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., (2006). 90, 128 дахь тал

⁵ Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь., (2022). 204 дэх тал

⁶ <https://legalinfo.mn/mn/detail/11703>

⁷ <https://legalinfo.mn/mn>

“Захиргаа нэг талаас нийтийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх замаар нийтэд үйлчлэх /Public service/, тэрчлэн нийтийн ашиг сонирхол /Public interests/-ын тусын тулд ажиллах ёстой нийтийн үйлчилгээний шинжлэх ухаанч судлагдахуун мөн⁸. Нөгөө талаас засаг захиргааны болоод салбарын удирдлагыг хэрэгжүүлэхдээ иргэдийн эрх ашгийг хангах, хамгаалах, нийтийн ашиг сонирхолд үйлчлэх, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулахаар хэм хэмжээний нийлбэр цогцоор нөхцөлддөг байна.

Мөн захиргааны байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллага юм⁹. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн иргэдийн эрхийг нь хөндсөн захирамжилсан шийдвэр гаргадаг байгууллагыг ойлгож болохоор байна. Мөн түүнчлэн багш Д.Ганзориг “Захиргааны байгууллага гэж” үйл ажиллагаа нь нийтийн эрх зүйн хүрээнд явагдах бусдыг /иргэн, хуулийн этгээдийг/ хуулиар олгогдсон эрх мэдлийн үндсэн дээр засаглан захирамжлах зорилго нь нийтийн ашиг сонирхолд чиглэгдэх байгууллага” гэж тодорхойлсон байна.

Захиргааны ерөнхий хуулийн 5.1-д заасан тодорхойлолтоос үзэхэд захиргааны байгууллага бол нийтийн эрх зүйн харилцаанд оролцохдоо нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд иргэн, хуулийн этгээдийг захирамжлах шийдвэр гаргадагт уг байгууллагын онцлог оршино. Нэгэнт нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэгтэй тул нийтийн эрх зүйн этгээд байна. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага /гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх/ нь амьдралын олон төрлийн харилцааг бүгдийг хамарсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд эдийн засгийн, нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн, хууль зүйн, боловсролын, хөдөө аж ахуй, газар тариалан, хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга, эрчим хүч гээд хамаарахгүй салбар, хүрээ байдаггүй¹⁰ байна. Эндээс харахад, захиргааны үйл ажиллагаа *хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах* гэсэн хүрээгээр хязгаарлагдаагүй болох нь харагдаж байна.

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах маргаан шүүхэд гарахад түүнийг төлөөлөх эрхийн хүрээг явцууруулж эрх зүйн зохицуулалт хийсэн нь эрх зүйн алдаа болсон байна гэж дүгнэхээр байна. Өөрөөр хэлбэл нийтийн эрх ашгийн хүрээ хязгаарыг зөвхөн “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч” гэж явцууруулан зохицуулалт хийсэн нь эрх зүйн алдааг бий болгосон байна.

Нийтийн ашиг сонирхол нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийн асуудлаар хязгаарлагдахгүй түүнээс гадна өв соёл, урлаг, уламжлал, нийгмийн халамж, шинжлэн ухаан, үндэсний эв нэгдэл, дэд бүтэц, боловсролын зэрэг асуудлаар хуульд заасан шаардлагыг хангасан этгээд захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг хамгаалан нэхэмжлэл гаргах эрхтэй. Үүнийг дараах ганцхан жишээгээр нотолъё: “нийгмийн халамж”.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн

⁸ Ш.Цогтоо., Монгол улсын захиргааны эрх зүй., (2021)., 17 дахь тал

⁹ Монгол улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар., (2017)., УБ., 76 дахь тал

¹⁰ Монгол улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар., (2017)., УБ., 74 дэх тал

хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”¹¹ гэж заасан байна. Энэ нь төрийн эдийн засагт зохицуулалт хийх нэг зорилго бөгөөд хүн амын нийгмийн хөгжлийг хангах явдал юм. Уг зорилгын хүрээнд ядуурлыг бууруулах, амьдралын чанарыг сайжруулах бодлого хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан нь дээд зарчим тул нийтийн ашиг сонирхлыг дагалдах хувь этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах, хангах нь нийтийн үүрэг даалгаварт хамаарч байдаг. Жишээ нь: нийгмийн халамж¹².

Дэлхий дахинаа төрд итгэх иргэдийн итгэл суларч, чадавх нь буурсаар байгаа ч зөвхөн төр л хийж чадах зүйлс бий. Байгалийн гамшиг, гэнэтийн дампуурал, ажилгүйдлийн үед зах зээл өөрөө өөрийгөө зохицуулж чадахгүй, Эдгээрт зах зээлийн шийдэл гэж үгүй, Төр буюу засгийн газар бусад институтын шийдвэрлэж чадахгүй асуудлыг шийдэхийн тулд оршин тогтнодог¹³. Тэрхүү асуудлуудын нэг нь тэгш бус байдал мөн. Тэгш бус байдлыг зах зээл зохицуулна гэж үгүй бөгөөд харин ч баян ядуугийн хоорондын ялгаа улам бүр ихэсгэхэд нөлөөлдөг. Тэгэхээр төр дундаж болон ядуу, нэн ядуу давхаргын иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн зохицуулалт хийх үүргийг хүлээдэг. Тэгш бус байдлыг бууруулах зохицуулалтыг хийх нь аж ахуй бүх хэвшлийн хөгжлийг хангах зорилгод нийцэх бөгөөд тэгш бус байдлыг бууруулах үндсэн зорилго нь хүн амын нийгмийн хөгжлийг хангахад чиглэж байх тул хүнд дундаж болон ядуу, нэн ядуу давхаргын иргэдийн амьдралын чанарыг сайжруулж, тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн төрийн зохицуулалт хийх нь Монгол Улсын Үндсэн хуулийн эдийн засгийн суурь үзэл баримтлалд нийцсэн байна¹⁴. Түүнчлэн нийгмийн халамжийн бодлогын хүрээнд олон улсын нэгдэн орсон гэрээ эрх зүйн зохицуулалтыг судалж үзвэл: “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх эрхтэй”¹⁵, “хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө”¹⁶, “өндөр наслах, хөдөлмөрлөх чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”¹⁷ гэж заасан байна.

Түүнчлэн, Монголын эртний хууль цаазын бичиг “Их цааз” зэрэг түүхэн эх сурвалжид өтгөс буурал, ядуус, өнчин иргэдийг энэрэн тэтгэх тухай зохицуулалт хийгдсэн уламжлал хүртэл байна. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2012 он нийгмийн халамжийн тухай хууль шинэчилсэн найруулга хийгдсэн байна. Мөн Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засгийн, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй гэж заасан¹⁸ байна. Дээрхээс үзэхэд хувь хүн өндөр наслах, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэхдээ төрөөс тусламж дэмжлэг авах, нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах эрхээ эдлэх, түүнтэй холбоотой захиргааны байгууллага нийтийн эрх ашиг сонирхлыг илэрхийлсэн шийдвэр, үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлдэг уламжлал шинэчлэл манай улсад байна.

Энэ харилцаанаас нийтийн ашиг сонирхол хөндөгдвөл энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь: Захиргааны хэрэг

¹¹ <https://legalinfo.mn/mn/detail/367>

¹² Монгол улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар., (2017)., УБ., 71 дэх тал

¹³ Дуфло Эстер, Банержи Абхжит нар., Орчуулагч Б.Дөлгөөн, Хүнд үеийн эдийн засаг, (2021) 301 дэх тал /дам эшлэв/

¹⁴ Х.Буянбат., Монгол Улсын Үндсэн хуулийн эдийн засгийн суурь үзэл баримтлал нь хүнд үеийг даван гарах гарц болон нь., Үндсэн хууль ба эрх зүйт ёс XIV., 60 дахь тал

¹⁵ Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 22 дугаар зүйл

¹⁶ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 9 зүйл

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь заалт

¹⁸ Хүний эрхийн товч тайлбар., (2013)., УБ., 98 дахь тал

шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж зааснаар зөрчигдөж байна. Мөн түүнчлэн нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байдаг болов уу? Сонирхол татаад судалж үзэхэд

Хөгжил ба Туслалцааны Байгууллага "АДРА": “Үндсэн дөрвөн чиглэл болох хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол болон гамшгийн менежментийн хүрээнд Эдийн засгийн тогтвортой хөгжилд туслах, эрүүл мэнд, боловсролын салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нийгмийн хөгжилд зориулсан төрөл бүрийн төсөл хэрэгжүүлэх, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур иргэдэд буцалтгүй тусламж үзүүлэх ажил зохион байгуулж ажиллах” Боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг,

"Сэлвэйн Арми": Нийгмийн халамжийн чиглэлээр өндөр настан болон хүүхдийн асрамжийн төв, өдөр өнжүүлэх ажиллуулах, хоол хүнс, тусламжийн бараа түгээх, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, ийм өвчтэй хүмүүст туслах, боловсрол, соёлын чиглэлээр сургалт семинар зохион байгуулах, газар тариалан эрхлэхэд иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд байна,

“Монголын хүүхдийн сан”: Орон гэргүй, гудамжны хүүхдүүдийг орон байраар хангах, тэдний оюун ухаан болон бие махбодын хэрэгцээг хангаж, анхаарал халамж тавих, эмзэг бүлгийн айл өрхийн хүүхдүүдийг цаашид гудамжны амьдралд оруулахгүйн тулд туслалцаа үзүүлэх, адил зорилго бүхий байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой,

"Тайвны хүүхэд гэр төрийн бус байгууллага бүлийг дэмжих сан": *Амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой өрхийн эдийн засгийн чадавхыг сайжруулах*, тэдгээр өрхийн хүүхдүүдийн эсэн мэнд амьдрах эрхийг хамгаалах, сургууль завсардахгүй суралцуулах зорилготой төрийн байгууллагуудыг дурдаж болох юм.¹⁹ Гэх мэтээр жагсаалт үүсгэж болохоор байна. Мөн манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа нь нийгмийн олон салбарт олон чиглэлээр явуулж байгаа нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл Монголд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагаа зөвхөн хүүхдийн эрх, байгаль орчин, нийтийн өмч, нийтийн эрүүл мэнд чиглэлээр хязгаарлагдахгүй болох нь харагдаж байна. Иймээс захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад хуульчилсан байхад: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”, гэж заасан нийтийн ашиг сонирхлыг явцууруулан тайлбарлаж. Бусад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар хуулийг шаардлага хангасан этгээд (төрийн бус байгууллага) шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарласан байна. Өөрөөр хэлбэл хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийн асуудлаас өөр зөрчигдөх, зөрчигдөж болзошгүй нийтийн ашиг сонирхол байна. Мөн түүнийг төлөөлөх хуулийн шаардлага хангасан (тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага) байхад Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл

¹⁹ <https://immigration.gov.mn/mn/trijn-bus/>

баримтлал, захиргааны эрх зүйн онол баримтлалыг үл харгалзан эрх зүйн зохицуулалтын алдаа гаргасан байна.

Хэдийгээр Монгол Улсын Дээд шүүх: (Монгол Улсын Үндсэн хуулийн 50.1-т “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, Монгол Улсын шүүхийн тухай хуулийг 25 дугаар зүйлийн 25.8-д зааснаар Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар даарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 25.8.4. шүүхийн шийдвэр практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах) Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг Монгол улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 30 дугаар тогтоолоор тайлбарласан боловч тухайн тайлбарыг судлаад үзэхэд: Уг тайлбарын 2.2 Хуулийн 3.1.9 “Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг” гэж, 18 дугаар зүйлийн 18.3-т “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна”- гээд 18.3.1-д “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийсэн байх, 18.3.2-т заасан “ дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэж заажээ.

Нээлттэй нийгэм форумаас “Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик” сэдэвт судалгаа хийгдсэн бөгөөд уг судалгаанаас үзэхэд: Нийтийн ашиг сонирхолд хамааралтай гэж үзсэн 15 шүүхийн шийдвэрийг судлахад 10 шийдвэрт нэхэмжлэгч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй талаар дүгнэлт өгсөн, үлдэх 5 шийдвэрт огт дүгнэлт өгөөгүй.

Нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий этгээд мөн эсэхийг нотлох ажиллагаа хийлгүйгээр захиргааны хэрэг үүсгэн улмаар нэхэмжлэлийн шаардлагыг хангасан. Үйл ажиллагааны тайлангаа улсын бүртгэлийн байгууллагад заавал хүргүүлсэн байх, санхүүгийн тайланг нэхэмжлэлд хавсаргасан байх татвар төлсөн зэрэг бусад төрийн бус байгууллагад нийтлэг байдлаар тавьдаг шаардлагыг зарим тохиолд шүүх шаардаагүй. Шүүхийн шийдвэрт Төрийн бус байгууллагын дүрмийн зорилго нь нэхэмжлэгчийн шаардлагатай нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөлгүйгээр зөвхөн байгуулагдсан огноог дүрмийн зорилгын хамт дурдаад өнгөрсөн. 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсныг нотлох төдий үнэлэх, эсвэл хамааралгүй үйл баримтад үндэслэн дүгнэлт хийгдсэн байна. Дээрх судалгааны дүгнэлтэд “,,,нэхэмжлэл гаргах эрхийг ийм тодорхойгүй шалгуураар тогтоох нь Төрийн бус байгууллагын дунд төөрөгдөл үүсгэх, буруу жишиг тогтоох эрсдэлтэй, ингэснээр дараа дараагийн төрийн бус байгууллагууд энэхүү буруу жишигт үндэслэн нэхэмжлэл гаргах, түүнийг нь шүүх хүлээн авахгүй байх, цаашлаад нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй гэж дүгнэсэн байна. Дээрхээс харахад, Монгол Улсын Дээд шүүх албан ёсны тайлбар хийсэн боловч: Улсын Дээд шүүх хүчин төгөлдөр хуулийг тайлбарлах үүрэгтэй ч хууль тогтоох эрх мэдлийн хил хязгаар руу халтиран орох эрхгүй байдаг нь харагдаж байна.

“Тайлбарлах гэдэгт” шаардлагатай гэж үзсэн эрх зүйн хэм хэмжээг утга агуулга, хэллэг, нэр томъёог нийтээр нэг мөр ойлгоход дөхөм болсон тодруулга, тайлал хийж, хэрэгжилтийг хамгийн зөвөөр хангахад чиглэсэн олон талст үйл ажиллагаа хамаардаг. Иймээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөх эрх бүхий этгээдийн талаар тайлбар хийхдээ: Нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий этгээд мөн эсэхийг нотлох талаар тайлбар

хийсэн байна. Улсын дээд шүүхэд тухайн эрх зүйн зохицуулалтыг тайлбарлах хэрэгцээ шаардлага үүссэн боловч хууль тогтоох эрх мэдлийн хил хязгаар руу халтиран орох эрхгүйгээс хүчин төгөлдөр хуулийн хүрээнд тайлбар хийсэн байна. Иймээс Улсын дээд шүүхийн тайлбараар эрх зүйн алдааг засах боломжгүй нь харагдаж байна.

Дүгнэлт, санал

“Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж хуульчилсан нь:

“Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна” гэж заасныг (тухайн хуулийн үзэл баримтлалыг) үл харгалзан нийтийн ашиг сонирхлыг явцууруулан тодорхойлж, хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалахаас бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг (нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар хуулийг шаардлага хангасан этгээд) төрийн бус байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарласан байна. Өөрөөр хэлбэл, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж хуульчилсан нь эрх зүйн алдааг бий болгосон байна.

Эрх зүйн алдаа нь нийгмийн харилцааг зохицуулахдаа бодит байдлыг зөв үнэлж, дүгнээгүйгээс эрх зүйн хэм хэмжээг буруу тогтоосон, өөрөөр хэлбэл тухайн эрх зүйн хэм хэмжээг буруу бүтээсэн байдлыг ойлгоно²⁰. Эрх зүйн алдаа янз бүрээр илэрдэг. Тухайлбал, эрх зүйн хэм хэмжээнд тавьдаг агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангаагүй зөрчсөн байх²¹ юм.

“Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж хуульчилсан нь: эрх зүйн хэм хэмжээнд тавьдаг агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангаагүй байна. Эрх зүйн алдааг засаж залруулж болдог. Засаж залруулах арга зам нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, албан ёсны тайлбар хийх замаар зөвтгөж болдог.

Улсын дээд шүүхэд тухайн эрх зүйн зохицуулалтыг тайлбарлах хэрэгцээ шаардлага үүссэн боловч хууль тогтоох эрх мэдлийн хил хязгаар руу халтиран орох эрхгүйгээс хүчин төгөлдөр хуулийн хүрээнд тайлбар хийсэн байгааг дээр дурдсан. Иймээс Улсын дээд шүүхийн тайлбараар эрх зүйн алдааг засах боломжгүй нь харагдаж байна. Ер нь эрх зүйн хийдэл, алдаа, зөрчилдөөн буюу коллизм аль аль нь нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтын нэр хүндийг доройтуулж, доктор Ч.Нямсүрэнгийн хэлснээр “,, эрхзүйн “инфляц” буюу ханш уналтыг”²² бий болгодог ноцтой үзэгдэл мөн. Иймээс шинжлэх ухаанч ага барилаар аль болох цаг алдалгүй засаж залруулж байх ёстой. Тэгсэн нөхцөлд

²⁰ О.Амархүү., Эрх зүйн онол. (2018). УБ. 253 дахь тал

²¹ О.Амархүү., Эрх зүйн онол. (2018). УБ. 254 дахь тал

²² Ч.Нямсүрэн., Эрх зүйн ерөнхий онол. Хоёр дахь. УБ. (2017), 318 дахь тал

эрх зүйт төрийн мөн чанар онол, практикийн аль ч талаасаа амьдралд бодитойгоор илрэн хэрэгжинэ.²³

Мөн шүүх эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ (тодорхой асуудлыг шийдвэрлэхдээ) түүнд зориулагдсан заалтыг шууд үндэс болгож шийдвэрээ гаргадаг²⁴ иймээс практикт үүсэх үр дагаврыг бас анхаарах хэрэгтэй. Практикт үүсэх үр дагавар болон онолын үзэл баримтлал, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал зэргийг судлаад тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, боловсронгуй болгох дараах саналыг дэвшүүлж байна.

2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж хуульчилсныг шинэчлэн найруулах нь зүйтэй байна.

Ашигласан материал

1. О.Амархүү, Эрх зүйн онол. 2018.
2. Х.Буянбат, Монгол Улсын Үндсэн хуулийн эдийн засгийн суурь үзэл баримтлал нь хүнд үеийг даван гарах гарц болон нь., Үндсэн хууль ба эрх зүйт ёс XIV.
3. Дуфло Эстер, Банержи Абхижит нар., Орчуулагч Б.Дөлгөөн, Хүнд үеийн эдийн засаг, 2021.
4. Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь, 2022.
5. Монгол улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017.
6. Хүний эрхийн товч тайлбар, 2013.
7. Ш.Цогтоо, Монгол улсын захиргааны эрх зүй, 2021.
8. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал. Тэргүүн дэвтэр, 2000.
9. Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс, 2006.

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Захиргааны ерөнхий хууль (2015)
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
4. Хууль тогтоомжийн тухай хууль (2015)
5. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>
2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар: <https://immigration.gov.mn/mn/trijn-bus/>
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.1212.mn/mn>
4. <https://legaldata.mn/>

²³ О.Амархүү., Эрх зүйн онол. (2018). УБ. 258 дахь тал

²⁴ Б.Чимид., Үндсэн хуулийн мэдлэг. (2008). 49 дэх тал

